

**“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-г баталсан. Уг тогтоолын 2 дахь хэсэгт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар “Транспэрэнси Интернэшнл” байгууллагын судалгаагаар Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт өмнөх оныхоос буурсан шалтгааныг арилгах арга хэмжээ тогтоолын төсөлд хэрхэн туссан болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг улс төрийн намын санхүүжилтийн талаар, мөн сонгуулийн зардлыг бууруулах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хөтөлбөрөөс гарах эцсийн үр дүн, хэмжих шалгуурын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар авлигад өртөж болзошгүй төрийн дунд шатны алба хаагчдад чиглэсэн бодлого, арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, шинэ шатанд гаргах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг сонгууль дахь мөнгөний нөлөөг бууруулах, албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх ач холбогдлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр

болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэг нь нийтийн албан тушаалтны дунд шатанд орхигдолгүй хэрэгжиж, авлигыг бүх талаар таслан зогсоох зарчмыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг нь болохыг анхаарах талаар үг хэлсэн болно.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Д.ЦОГТБААТАР